

13

ҮҮСМЭЛ ХЭРЭГЛҮҮРИЙН БҮРТГЭЛ

Ч.Оюун-цэнд

1970 оны эхэн үеэс эхлэн зах зээлийн хөгжил, шинэ технологи, хууль эрх зүйн өөрчлөлтүүд бизнесийн эрсдлийг нэмэгдүүлсээр ирсэн. Үүний хариулт болгон санхүүгийн байгууллагууд эдгээр эрсдлүүдийг удирдах зорилгоор шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлсээр байна.

Эдгээр бүтээгдэхүүнүүдийг **санхүүгийн үүсмэл хэрэглүүр** буюу **дераватив** гэж нэрлэх ба эдгээр нь эрсдлийг удирдахад өргөн хэрэглэгдэж байна.

1. Үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох.

Деравативийг ойлгохын тулд дараах жишээг авч үзье. *Жишээ 1- Forward гэрээ.* Lenovo (Хятад) компани Google's (АНУ)-ийн хувьцаа ирэх 3 сард ихээхэн хэмжээгээр өснө гэж найдаж байгаа. Харамсалтай нь Lenovo компаний хувьд өнөөдөртөө хувьцааг худалдан авах мөнгөний нөөц байхгүй байгаа учраас үнэт цаасны брокертой Google's-ийн хувьцааг дараагийн 3 сард нэгжийг нь \$110 –оор худалдан авах гэрээг хийнэ.

Lenova *Forward гэрээ* буюу деравативийн нэг хэлбэрийг ашиглаж байна гэсэн үг юм. Энэхүү гэрээгээр Lenovo компани Google's-ийн 10000 ш хувьцааг дараагийн 3 сард худалдан авах **эрхтэй**, нэгж хувьцааг \$110 – оор худалдан авах **үүрэгтэй** болж байна. Энэхүү дераватив гэрээний үр өгөөж нь юу вэ? Lenovo компани Google's-ийн хувьцааг өнөөдөр худалдан авч болно эсвэл үүнийг 3 сарын хугацаанд хадгалж болно. Хэрэв үнэ өсвөл Lenovo-д ашигтай ба, үнэ унавал Lenovo алдагдалд орно.

Жишээ2- Option гэрээ. Одоо Lenovo компаний хувьд Google's-ийн хувьцааг худалдан авах эсэхээ шийдэхэд 2 долоо хоног хэрэгтэй байгаа. Энэ тохиолдолд 2 долоо хоногийн аль ч хугацаанд Google's-ийн хувьцааг өнөөдрийн үнээр худалдан авах эрхтэй өөр нэгэн гэрээг Lenovo хийж болно. Гэрээ ёсоор 2 долоо хоногийн туршид тогтоосон гэрээг үнээр барьж байгаагийнхаа төлөө брокер \$3000 ийг тооцож авна.

Lenova *Option гэрээ* буюу деравативийн нэг хэлбэрийг ашиглаж байна гэсэн үг юм. Энэ гэрээ ёсоор эдгээр хувьцааг худалдан авах **эрх үүссэн**

ч үүрэг үүсэхгүй. Хэрэв Google's-ийн хувьцааны үнэ дараагийн 2 долоо хоногт өсвөл Lenovo хувьцааг гэрээнд заасан үнээр худалдан авч *Option гэрээний* зардлыг нэмж төлнө. Хэрэв хувьцаан үнэ өсөхгүй бол Lenovo хувьцааг худалдаж авахгүй байж болох ч *Option гэрээний* зардлыг төлөх ёстой.

Forward гэрээ, Option гэрээ хоёулаа хувьцааны ирээдүйн худалдан авалттай холбоотой байдаг. Гэрээний үнэ цэнэ нь Google's-ийн хувьцаа буюу хөрөнгөөс хамаарна. Тийм учраас бусад хөрөнгийн (хувьцаа, бонд, бараа гм) үнэ цэнээс үүсдэг учраас эдгээр санхүүгийн хэрэглүүрийг үүсмэл хэрэглүүр (дериватив) гэж нэрлэсэн байна. Өөр нэг талаас авч үзвэл эдгээрийн үнэ цэнэ нь зах зээлийн үзүүлэлттэй (хувьцааны үнэ, хүүгийн төвшин эсвэл Лондонгийн хөрөнгийн биржийн индекс гм) холбоотой байдаг.

Дараах 3 төрлийн деривативийн талаар авч үзнэ:

1. Санхүүгийн Forwards эсвэл Санхүүгийн Futures гэрээнүүд
2. Options-Опцион
3. Swaps-Солилцоо

2. Хэн, яагаад үүсмэл хэрэглүүрийг хэрэглэдэг вэ?

Хүүгийн төвшин, цаг агаар, хувьцааны үнэ, газрын тосны үнэ, гадаад валютын өөрчлөлтүүдээс хамгаалахын тулд деривативийн гэрээнүүд эдгээр төрлийн эрсдлээс гарах хэлбэлзлийг багасгахад ашиглагддаг. Компаниуд эдгээр бизнесийн эрсдлийн эсрэг өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд дериватив гэрээг ашигладаг байна⁶¹.

Үйлдвэрлэгч ба Хэрэглэгч

Heartland Ag компани нь томоохон төмс үйлдвэрлэгч бөгөөд төмсөө зах зээлд нийлүүлдэг. Төмсний одоогийн үнэ үйлдвэрлэгч компаний хувьд хамгийн таатай байгаа. Харамсалтай нь Heartland компаний хувьд төмсөө хураагаад, зах зээлд нийлүүлэхэд 2 хоног шаардлагатай байгаа учраас Forward гэрээг хийнэ. Энэ гэрээ нь хоёр сарын дараа одоогийн зах зээлийн үнээр төмсөө нийлүүлэх тухай өнөөдөр хийх гэрээ юм.

Хэн гэрээг худалдан авах вэ? Гэрээний нөгөө тал нь Mcdonald's (АНУ) компани 2 сарын дараа төмс (шарсан төмсөнд зориулан) авах хүсэлтэй бөгөөд төмсний үнэ 2 сарын дараа өснө гэж үзэж байгаа. Mcdonald's 2 сарын дараа төмсийг өнөөдрийн үнээр худалдан авахыг зөвшөөрнө гэсэн үг юм. Төмсийг өнөөдрийн үнээр худалдан авснаарх ашигтай ажиллана гэдгээ Mcdonald's компани тооцоолсон байгаа.

Энэ тохиолдолд хэрэв төмсний үнэ хүргэлтээс өмнө өсвөл Heartland алдаж, Mcdonald's хожно. Эсрэгээр үнэ буурвал Heartland хожиж, Mcdonald's алдана. Гэхдээ энэ нь ямар нэгэн бооцоо биш юм. Үнэ хаашаа ч хэлбэлзсэн 2 компаний хувьд боломжийн ашиг хүртэнэ. Энэ тохиолдолд

⁶¹ Деривативууд олон улсны хэмжээнд худалдаалагдаж байдаг. Түүнчлэн маш олон дериватив гэрээнүүд (хүүгийн төвшний солилцоонд) хувийн журмаар хийгддэг байна.

хэдийгээр Heartland **үйлдвэрлэгч**, Mcdonald's **хэрэглэгч** ч гэсэн хоёулаа **хамгаалагчид** юм. Хоёулаа л боломжийн санхүүгийн үр дүнд хүрэхийн тулд өөрсдийн байдлаа хамгаалж байна.

Цаг агаар, ургац хураалт, ерөнхий эдийн засгийн байдлаас хамаараад барааны үнүүд тогтворгүй байдаг. Үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хувьд ирээдүйд бизнесээ амжилттай явуулахын тулд ирээдүйн орлого зардлаа тодорхой болгон хамгаалах нь зүйн хэрэг юмаа.

Наймаачин (speculator) ба Худалдаачин (arbitrageur)

Зарим тохиолдолд Mcdonald's компаний оронд наймаачид Heartland компаниас гэрээг худалдан авч болно. Наймаачин төмсний үнэ өссөнөөр Forward гэрээний үнэ цэнэ өснө гэж тооцсон. Наймаачин гэрээг хэдхэн цаг ч хамаагүй зах зээлд байлгаж байгаад өөр нэг наймаачинд эсвэл Mcdonald's шиг өөр нэгэн компанид зарж болно.

Худалдаачид мөн деравативийг ашигладаг. Эдгээр зах зээлд тоглогчид зах зээлийн үр ашиггүй байдлыг ашиглахыг чармайдаг. Худалдаачид хоёр түүнээс олон зах зээлд зэрэг ажилладаг. Жишээ нь худалдаачин Future гэрээнд оролцох ба үүнтэй зэрэг Future гэрээнд заасан барааг зэрэг зарж болдог. Ингэснээр энэ 2 ийн бага хэмжээний зөрүүгээс ашиг олох боломжтой. Зах зээл нь наймаачин, худалдаачдын өдөр тутмын зах зээлийн өөрчлөлтөөс хамаардаг байна. Heartland, Mcdonald's –аас гадна бусад компани деравативийг хэрхэн ашигладаг талаарх жишээнүүд:

1. Агаарын тээврийн компаниуд: Japan Airline (Япон), British Airline (Англи), Delta (АНУ) –уудад түлшний үнийн өөрчлөлт нөлөөлдөг.
2. Санхүүгийн байгууллагууд: Barclays (Англи), Bankers Trust (АНУ), INC (Голланд) –уудад хүүгийн төвшний өөрчлөлт зээл олгох болон зээлдүүлэх сангуудад нөлөөлдөг.
3. Үндэстэн дамнасан компаниуд: Nokia(Финланд), Coca Cola (АНУ), Siemens(Герман) валютин ханшны өөрчлөлт нөлөөлдөг.

Бодит байдал дээр ихэнх компаниуд деравативийн зарим хэлбэрийг ашигласан байдаг. Компаниуд яагаад үүнийг ашигласан шалтгаанаа жилийн тайландаа оруулсан байдаг:

1. ExxonMobile (АНУ) хүүгийн төвшин, гадаад валютын ханшны зөрүү, нүүрсустөрөгчийн үнийн хэлбэлзлээс хамгаалахын тулд деравативийг ашигладаг.
2. HSBC (Англи) хүүгийн төвшин, гадаад валютын ханшны зөрүүгийн хэлбэлзлийг удирдахын тулд деравативийг ашигладаг.
3. GlaxoSmithKline (Англи) хүүгийн төвшин, гадаад валютин ханшны зөрүү цэвэр ашиг болон мөнгөн урсгалд нөлөөлдөг тул түүнийг удирдахад ашигладаг.

Маш олон компаниуд деравативийг өргөн хэмжээгээр, амжилттай хэрэглэж байна. Гэсэн хэдий ч дераватив нь аюултай байж болох юм.

Гэрээнд оролцогч талууд эдгээр гэрээтэй холбоотой эрсдэл, өгөөжийг зөв ойлгох ёстой байдаг⁶².

3. Үүсмэл хэрэглүүрийн бүртгэлийн үндсэн зарчмууд

Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Хороо (International Accounting Standard Board-IASB) –ноос Forward болон Option зэрэг деравативууд нь нь байгууллагын хөрөнгө юм гэж заасан байдаг. Компаниуд эдгээрийг санхүүгийн байдлын тайланд **бодит үнэ цэнээр**⁶³ тайлагнах ёстой гэж заажээ. Бодит үнэ цэнээрх мэдээлэл нь санхүүгийн тайланг хэрэглэгчдэд деравативийн талаар үнэн зөв мэдээллийг өгч чадна хэмээн Зөвлөл үздэг байна. Зарим тохиолдолд деравативийг түүхэн өртгөөр үнэлэн, харуулсан байдаг нь утгагүй юм. Яагаад? Учир нь олон деравативийн хувьд түүхэн өртөг нь 0 байдагтай холбоотой. Цаашилбал дераватив хэмээн үзсэн эдгээр хөрөнгийн үнэ цэнэ нь зах зээлээсээ ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс Зөвлөл деравативийг боломжит бодит үнэ цэнээр тодорхойлохыг шаарддаг⁶⁴.

Хэрэв компани деравативийг наймааны зорилгоор ашиглаж байвал түүний хэрэгжээгүй олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ёстой. Харин деравативийг хамгаалалтын зорилгоор ашиглаж байвал бүртгэлийн олз гарз нь хамгаалалтийн ямар аргыг ашигласнаас хамаардаг.

Компани деравативийн бүртгэлдээ дараах заарварчлагааг дагаж мөрдөнө:

1. Деравативийг санхүүгийн тайланд хөрөнгөөр эсвэл өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.
2. Деравативийг бодит үнэ цэнээр тайлагнана.
3. Деравативийн наймаанаас бий болсон олз, гарзыг орлогын тайланд шууд хүлээн зөвшөөрнө.
4. Хамгаалалтын гүйлгээнээс бий болсон олз, гарзыг хамгаалалтын аргаас хамааран өөрөөр тайлагнана.

⁶² Нилээд олон нэр хүндтэй компаниуд деравативийг ашиглан ихээхэн хэмжээний алдагдалд орсон байдаг. Жишээ нь Fannie Mae(АНУ), Enron (АНУ), Showa Shell Sekiya (Япон), Metallgesellschaft (Герман), Procter & Gamble (АНУ), Air Products & Chemicals (АНУ) компаниуд деравативийг ашигласнаар ихээхэн хэмжээний алдагдалд оржээ.

⁶³ Санхүүгийн Тайлагналын Олон Услын Стандарт-СТОУС бүх санхүүгийн болон санхүүгийн бус үүсмэл хэрэглүүрийн бүртгэл тайлагналын стандартаар хангасан байдаг.

⁶⁴Бодит үнэ цэнэ гэдэг нь зохих мэдлэг бүхий, холбоогүй арилжаанд оролцогч талуудын хооронд хөрөнгийг солилцох үнэ гэж тодорхойлсон байдаг. Иймээс бодит үнэ цэнэ нь зах зээлд суурилсан хэмжигдхүүн юм. ОУНББС Хорооноос бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглах үнэлгээний аргачлал болох бодит үнэ цэнийн шатлалыг үзүүлсэн байна. *Төвшин 1.* Бодит үнэ цэнэ идэвхтэй зах зээл дэх тодорхой хөрөнгө, өр төлбөрийн тогтоосон, ажиглагдхуйц үнээр хэмжих. *Төвшин 2.* 1-р төвшин дах тогтоосон үнээс бусад ажиглагдхуйц үнэ дээр үндэслэн хэмжигдэнэ. *Төвшин 3.* Ажиглаж болохгүй үнэ (компаний өөрийн өгөгдөл эсвэл төсөөлөл) дээр суурилла. Тиймээс, Төвшин1 ийг хамгийн найдвартай үнэ гэж үзэх бөгөөд “Санхүүгийн мэдээ” –нд нийтлэгдсэн хаалтын ханш байна. Төвшин 2 нь дараагийн найдвар бүхий үнэ байх ба идэвхтэй зах зээл дэх төстэй хөрөнгө, төлбөрийг үнэлэх замаар бодит үнэ цэнийг тооцно. Төвшин 3 нь хамгийн бага найдвар бүхий үнэ бөгөөд олж болох, боломжит хамгийн сайн мэдээлэл дээр үндэслэнэ.

Жишээ: Дериватив Санхүүгийн хэрэглүүр (Наймаа)

Наймааны зорилгоор ашиглаж буй деривативийн хэмжилт, тайлагналыг харуулахын тулд “Л” компаний энгийн хувьцааны зах зээлийн үнээс хамаарсан деривативийг авч үзье. “А” компани “Л” компаний энгийн хувьцааны үнэ өсвөл олз олох дериватив буюу “Call” опционыг ашиглаж байгаа. “Call” опцион нь эзэмшигчдээ хувьцааг урьдчилан тогтоосон үнээр худалдан авах **эрх** өгдөг ч **үүрэг** хүлээлгэдэггүй. Энэ урьчилан тогтоосон үнийг **цохилтийн үнэ** буюу **хэрэгжүүлэх үнэ** гэдэг.

Жишээ нь “А” компани “В” хөрөнгө оруулалтын компанитай “Call” опционы гэрээ хийсэн ба уг гэрээгээр “Л” компаний энгийн хувьцааг нэгжийг нь \$100-оор худалдан авах хувилбартай гэрээ юм⁶⁵. Хэрэв “Л” компаний хувьцааны үнэ \$100 –оос дээш өсвөл “А” компани опционыг хэрэгжүүлж, хувьцааг нэгжийг нь \$100-оор худаладан авна. Харин хувьцааны үнэ хэзээ ч \$100-оос өсөхгүй бол энэхүү “Call” опцион нь ашиггүй юм.

Бүртгэлийн бичилт. “А” компани 2011/01/01 нд буюу “Л” компаний хувьцааны зах зээлийн үнэ нэгж нь \$100 байхад “Call” опционы гэрээг худалдан авсан. Гэрээгээр “Л” компаний 1000ш хувьцааг нэгжийг \$100-оор худалдан авах хувилбарыг санал болгосон. Опционы гэрээний хугацаа 2010/04/30 нд дуусна. “А” компани “Call” опционыг худаладан авахад \$400 төлсөн.

2011/01/02

Дт “Call” опцион 400

Кт Мөнгө

400

Энэ төлбөрийг **опционы хураамж** гэнэ. Энэ нь ихэвчлэн хувьцааг шууд худалдан авахаас хамаагүй бага байдаг. Опционы хураамж нь 2 дүнгээс бүрддэг: (1) дотоод үнэ цэнэ, (2) хугацааны үнэ цэнэ.

$$\boxed{\text{Опционы хураамж}} = \boxed{\text{Дотоод үнэ цэнэ}} + \boxed{\text{Хугацааны үнэ цэнэ}}$$

Дотоод үнэ цэнэ гэдэг нь хугацааны ямар ч үед зах зээлийн үнэ болон урьдчилан тогтоосон цохилтын үнэ 2 ийн зөрүү юм. Хэрэв опционыг даруй хэрэгжүүлэхээр бол опционын эзэмшигч энэ дүнг харуулах боломжтой. 2011/01/02 нд зах зээлийн үнэ тогтоосон цохилтын үнэтэй тэнцүү тул дотоод үнэ цэнэ 0 байна.

Хугацааны үнэ цэнэ нь дотоод үнэ цэнээс давсан опционы үнэ цэнээр тодорхойлогдоно. Хугацааны үнэ цэнэ нь опционы 0-ээс илүү байгаа бодит үнэ цэнийн боломжоор илэрдэг. Яаж? Учир нь “Л” компаний хувьцаа гэрээний хугацаанд, цохиолтын үнээс дээш өснө гэсэн хүлээлт

⁶⁵ “В” хөрөнгө оруулалтын компанийг **оролцогч тал** гэх ба ихэвчлэн ороцогч тал нь хөрөнгө оруулалтын банкууд, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг эзэмшиж байгаа бусад компаниуд байдаг.

байдагтай холбоотой. Дээрх жишээнд опционы хугацааны үнэ цэнэ нь \$400⁶⁶ юм. Дараах “ Call” опционтой холбоотой нэмэлт мэдээлэл:

Огноо	"Л" компаний хувьцаан зах зээлийн үнэ	" Call" опционы хугацааны үнэ цэнэ
3/31/2011	\$ 120	\$ 100
4/16/2011	\$ 115	\$ 60

2011/03/31 нээр “Л” компаний хувьцааны үнэ өсөж \$120 болсон байна. Эндээс “ Call” опционы гэрээний дотоод үнэ цэнэ \$20000 болж байна. “А” компани “ Call” опционыг хэрэгжүүлж, “В” хөрөнгө оруулалтын компаниас 1000ш хувьцааг нэгжийг нь \$100 худалдан аваад \$120 –оор борлуулж болно гэсэн үг юм. Ийнхүү “ Call” опционы гэрээг⁶⁷ хэрэгжүүлснээр “А” компани \$20000 (\$120000-\$100000) олох боломжтой. Опционы дотоод үнэ цэнийн өсөлтийн “А” компани дараах байдлаар бүртгэнэ:

2011/03/31

Дт “ Call” опцион 20000

Кт Хэрэгжээгүй олз-Орлого 20000

2011/03/31 нээр зах зээл судлаачид опционы хугацааны үнэ цэнийг \$100⁶⁸ гэж үнэлсэн байна. “А” компани хувьцааны үнэ цэнийн бууралтыг дараах байдлаар бүртгэнэ:

2011/03/31

Дт Хэрэгжээгүй гарз-Орлого 300

Кт “ Call” опцион (\$400-\$100) 300

2011/03/31 нээрх санхүүгийн байдлын тайланд “ Call” опционыг бодит үнэ цэнэ болох \$20100⁶⁹ гаар тайлагнана. Хэрэгжээгүй олз нь тайлант үеийн цэвэр ашгийг нэмэгдүүлсэн бол опционы хугацааны үнэ цэнийн гарз нь цэвэр ашгийг бууруулна.

2011/04/16 нд “А” компани опционы хугацаа дуусахаас өмнө опционыг хэрэгжүүлсэн гэвэл хэрэгжүүлэхээс өмнө опционы дотоод үнэ цэнийн бууралтыг \$5000([\$20-\$15]*1000) бүртгэх ёстой:

2011/04/16

Дт Хэрэгжээгүй гарз-Орлого 5000

Кт “ Call” опцион 5000

⁶⁶ Опционы үнийн загварыг (Black-Scholes model)ашиглан энэ өртгийг тооцоолсон.

⁶⁷ Практикт ихэвчлэн хөрөнгө оруулагчид “Л” компаний хувьцааг худалдан авч, борлуулж олзыг хэрэгжүүлдэггүй. Харин гэрээний ирээдүйн цэвэр хэрэгжүүлэх дүнг харуулдаг.

⁶⁸ Үнэ цэнийн бууралт нь 2 зүйлээс шалтгаалан буурна: (1) “Л” компаний хувьцааны үнийн өсөлт гэрээний хугацаанд үргэлжлэх бол, (2)опционы гэрээний хугацаа дуусах гэж байгаа бол

⁶⁹ Хугацааны ямар ч үед опционы нийт үнэ цэнэ нь дотоод үнэ цэнэ дээр нэмэх хугацааны үнэ цэнэ байна.

Опционы хугацааны үнэ цэнийн бууралтыг \$40 (\$100-\$60) тооцон бүртгэнэ:

2011/04/16

Дт Хэрэгжээгүй гарз-Орлого 40
 Кт “ Call” опцион 40

“Call” опционыг хэрэгжүүлэх үед түүний дансны үнэ дараах байдалтай:

“ Call ” опцион			
2011/01/02	400	2010/01/02	300
2011/03/31	20,000	2011/04/16	5,000
		2011/04/16	40
Үлдэгдэл 15,060			

“А” компани “В” хөрөнгө оруулалтын компанитай хийсэн опционы гэрээг хэрэгжүүлсэн гэвэл:

2011/04/16

Дт Мөнгө 15000
 Дт “ Call” опционыг хэрэгжүүлсний гарз 60
 Кт “ Call” опцион 15060

Доор “ Call” опционы цэвэр ашигт үзүүлэх нөлөөг харуулж байна:

Огноо	Гүйлгээ	Цэвэр ашигт үзүүлэх нөлөө
3/15/2011	“ Call” опционы үнэ цэнийн цэвэр өсөлт (20000-300)	\$19,700
4/16/2011	“ Call” опционы үнэ цэнийн бууралт (5000+40)	-\$5,040
4/16/2011	“ Call” опционы хэрэгжүүлэлт	-\$60

Дээрх хүснэгтээр СТОУС-ийн дагуу “ Call” опционы НББ-ыг хураангуйлан харууллаа. Учир нь “ Call” опцион нь компаний хөрөнгийн шалгуурт нийцэж байгаа бөгөөд түүнийг 2011/03/31 нээр санхүүгийн байдлын тайланд бүртгэнэ. Түүнчлэн “ Call” опционыг бодит үнэ цэнээр тайлагнах ба олз, гарзыг орлогын тайланд харуулна.

Уламжлалт болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн ялгаа

Уламжлалт санхүүгийн хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүрээс (дериватив) яаж ялгардаг вэ? Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт дараах 3 үндсэн шинж байдаг:

1. Хэрэглүүрт нэг эсвэл хэд хэдэн сууриуд (underlying) болон тогтоосон төлбөрийн нөөц байдаг. Сууриуд гэдэг нь хүүгийн төвшин, аюулгүй үнэ, барааны үнэ, үнүүдийн эсвэл үнэлгээний индекс, бусад зах зээлтэй холбоотой хувьсах үзүүлэлтүүдийг тодорхойлон заасан байдаг.
2. Гэрээг эхлэх үед хэрэглүүр нь маш бага эсвэл хөрөнгө оруулалт хийхгүй. Өмнөх жишээн дээр “А” компани “Л” компаний хувьцааг худалдан авах шууд хөрөнгө оруулалтаас хамаагүй бага дүн буюу хураамжийг “Call” опционыг худалдан авахад төлсөн билээ.
3. Хэрэглүүр нь цэвэр хэрэгжүүлэлтийг шаарддаг буюу зөвшөөрдөг. “Call” опционы жишээ дээр “А” компани хувьцааг авалгүйгээр “Call” опционоос ашгийг хэрэгжүүлсэн. Энэ цэвэр хэрэгжүүлэлт нь деривативтай холбоотой гүйлгээний зардлыг бууруулдаг.

Дараах хүснэгтээр уламжлалт болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн ялгааг харуулсан байна. Уламжлалт санхүүгийн хэрэглүүрээр өмчөөрх хөрөнгө оруулалтыг, харин үүсмэл санхүүгийн хэрэглүүрээр “Call” опционыг сонгон харууллаа:

Онцлог	Уламжлалт санхүүгийн хэрэглүүр Өмчөөрх хөрөнгө оруулалт (худалдааны)	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр (“Call” опцион)
Төлбөрийн нөөц	Хувьцааы үнийг үржих нь хувьцааны тоо	Хувьцааны үнийн өөрчлөлтийг үржих нь хувьцааны тоо
Анхны хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулагч бүх зардлыг төлнө.	Анхны хөрөнгө оруулалт бүх зардлаас хамаагүй бага
Хэрэгжүүлэлт	Мөнгийг хүлээн авч хувьцааг хүргэнэ.	Хувьцааны үнийн өөрчлөлтийг үржих нь хувьцааны тоо дээр үндэслэсэн мөнгөтэй адилтгах зүйлийг хүлээн авна

4. Үүсмэл хэрэглүүрт хамгаалалтыг хэрэглэх нь.

Уламжлалт санхүүгийн хэрэглүүрийг бодвол дериватив нь ашиглахад хялбар, бага зардал шаарддаг учраас түүний хэрэглээ ихээхэн нэмэгдэж байна. Деривативийн хэрэглээнд эрсдлийн удирдлага чухал байдаг.

Coca-Cola(АНУ), BP (Англи), Siemens (Герман) компаниуд их хэмжээний мөнгийг санхүүгийн зах зээлээс зээлэх болон зээлдүүлдгээс ихээхэн хэмжээний **хүүгийн төвшний эрсдэл** хүлээдэг. Энэхүү эрсдэл нь хүүгийн төвшин өсөх, буурахад үүнд мэдрэмжтэй хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ болон мөнгөн урсгал ихээхэн хэмжээгээр өөрчлөгдөж илэрдэг байна. Энэ асуудалд нь үндэстэн дамнасан компаниудын хувьд ижил байдаг. Мөн **валютин ханшны эрсдлээс** үүдсэн гадаад валютин ханшны өөрчлөлт нь эдгээр олон улсан компаниудын ашигг ажиллагаанд сөрөгөөр нөлөөлдөг.

Компаниуд дээрх гадаад валютин ханшны өөрчлөлт болон хүүгийн төвшний өөрчлөлтийн эсрэг деравативийг ашигладаг. Энэ деравативийн хэрэглээг **хамгаалах** гэж нэрлэдэг.

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг Зөвлөлөөс-НББОУСЗ хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж буй дераватив санхүүгийн хэрэглүүрийн бүртгэл, тайлагналын стандартуудыг гаргасан байдаг. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-СТОУС нь хамгаалалтын 2 төрлийн бүртгэлийг зөвшөөрдөг⁷⁰:

1. Бодит үнэ цэнийн хамгаалалт
2. Мөнгөн урсгалын хамгаалалт

Бодит үнэ цэнийн хамгаалалт

Бодит үнэ цэнийн хамгаалалтын үед компани деравативийг хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр эсвэл, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэрээн дэх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болох нөлөөнөөс хамгаалахын тулд ашигладаг. Хамгаалалтыг сайн хийнэ гэдэг нь деравативийн бодит үнэ цэнийн олз, гарз нь хамгаалагдсан хөрөнгө, өр төлбөрийн бууралттай тэнцүү байхыг хэлнэ.

Компаниуд бодит үнэ цэнийн хамгаалалтын нэлээд олон төрлийг ашигладаг. Жишээ нь Хүүгийн төвшний өөрчлөлтийн эрсдлээс хамгаалахдаа хүүгийн төвшний солилцоог (interest rate swap) ашиглах нь зээлийн бодит үнэ цэнэд нөлөөлнө. Эсвэл өмчөөрх хөрөнгө оруулалтын эрсдлээс хамгаалахдаа “Put” опцтоныг ашиглах нь түүний үнэ цэнийг бууруулна.

Бодит үнэ цэнийн хамгаалалтийг харуулахын тулд 2011/04/01 нд “Н” компани “С” компаний хувьцааны зах зээлийн нэгж үнэ \$100 байхад 100 ш энгийн хувьцаа худалдан авсан гэж үзье. Хуулийн шаардлагаас болоод “Н” компани энэ хөрөнгө оруулалтыг идэвхтэй худалдаалахаар төлөвлөөгүй бөгөөд энэ хөрөнгө оруулалтыг худалдааны бус өмчөөрх хөрөнгө оруулалт гэж ангиласан. “Н” компаний журналын бичилт:

2011/04/01

Дт Өмчөөрх хөрөнгө оруулалт 10000

⁷⁰ НББОУСЗ мөн гадаад валютин тодорхой хамгаалалтын гүйлгээнүүдийн бүртгэлийн асуудлыг авч үзсэн /байдаг.

Кт Мөнгө 10000

“Н” компани санхүүгийн байдлын тайландаа энэ хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр бүртгэх ба хэрэгжээгүй олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдхүүнээр тайлагнана. “Н” компанид аз дайрч 2011 онд “С” компаний хувьцааны үнэ цэнэ \$125 болж өссөн байна. “Н” энэ хөрөнгө оруулалтын олзоо дараах байдлаар бүртгэнэ:

2011/12/31

Дт Бодит үнэ цэнийн тохиргоо 2500
Кт Хэрэгжээгүй олз-Өмч 2500

“Н” компани санхүүгийн байдлын тайландаа дараах байдлаар толилуулна:

“Н” компани Санхүүгийн байдлын тайлан 2011/12/31	
<u>Хөрөнгө</u>	
Өмчөөрх хөрөнгө оруулалт	\$12500
<u>Өмч</u>	
Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй орлого Хэрэгжээгүй олз	\$2500

Хэдийгээр “Н” компаний “С” компаний хувьцаан үнийн өсөлтөөс ашиг хүртсэн ч “С” компаний хувьцааны үнэ буурах эрсдэл байсаар байгаа юм. Энэ эрсдлээс хамгаалахын тулд “Н” компани “С” компани дах хөрөнгө оруулалтын олзоо авч үлдэхийн тулд “С” компани 100ш энгийн хувьцаан дах “Put” опционыг худалдан авна.

“Н” компани 2012/01/02 нд “Put” опционы гэрээг хийж, “С” компаний хөрөнгө оруулалтад бодит үнэ цэнийн хамгаалалтыг хийсэн. Энэ “Put” опцион(2 жилийн хугацаатай) нь “Н” компанид “С” компаний хувьцааг нэгжийг нь \$125-оор борлуулах хувилбарыг санал болгож байгаа юм. Нэгэнт хэрэгжүүлэх үнэнь одоогийн зах зээлийн үнэтэйгээ тэнцүү тул “Put” опционд ямар нэгэн журналын бичилт хийх шаардлагагүй юм⁷¹.

2012/01/02

Журналын бичилт хийхгүй. Харин “Put” опционы гэрээнд гарын үсэг зурсан болон “С” компани дах хөрөнгө оруулалтанд бодит үнэ цэнийн хамгаалалт хийсэн талаар тэмдэглэл хийнэ.

⁷¹ Жишээг энгийн болгохын тулд опционд төлөх хураамжийг тооцоогүй болно.

2012/12/31 нд “С” компани хувьцаан нэгжийн үнэ \$120 болж буурсан. “Н” компани “С” компани хөрөнгө оруулалтанд дараах журналын бичилтийг хийнэ:

2012/12/31

Дт Хэрэгжээгүй гарз-Орлого 500
Кт Бодит үнэ цэнийн тохиргоо 500

Хамгаалалт хийгдсэн ч СТОУС-ын дагуу “Н” компаний худалдааны бус өмчөөрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын хэрэгжээгүй гарзыг өмчид бус харин орлогын тайланд бүртгэнэ. Хэрэв “Н” компани энэ бүртгэлийг мөрдөөгүй бол орлогын тайлан дах олз, гарз нь уялдахгүй юм. Хамгаалагдсан зүйлийн (энэ тохиолдолд худалдааны бус өмчөөрх хөрөнгө оруулалт) энэ тусгай бүртгэл нь бодит үнэ цэнийн хамгаалалт хийхэд их чухал байдаг.

Дараах журналын бичилт нь “С” компаний хувьцаан дах “Put” опционы үнэ цэнийн өсөлтийн бүртгэлийг харуулна:
2012/12/31

Дт “Put” опцион 500
Кт Хэрэгжээгүй олз-Орлого 500

“С” компаний хувьцааны үнийн бууралт нь “Put” опционы бодит үнэ цэнийн өсөлтийг авчирна. Энэ нь “Н” компани зах зээлээс 100ш хувьцааг \$120-оор худалдан авч “Put” опционыг хэрэгжүүлэн, нэгжийг нь \$125-оор борлуулснаар “Put” опционы олзыг $500(100ш * (\$125 - \$120))^{72}$ хүлээн зөвшөөрнө.

“Н” компани “С” компани дах хөрөнгө оруулалт болон “Put” опционыг дараах байдлаар толилуулна.

“Н” компани Санхүүгийн байдлын тайлан 2012/12/31	
<u>Хөрөнгө</u>	
Өмчөөрх хөрөнгө оруулалт	\$12000
“Put” опцион	500

⁷² Практикт “Н” компани олзыг хэрэгжүүлэхийн тулд “С” компаний хувьцааг бодитоор худалдан авч борлуулдаггүй. Харин үүнийн оронд оролцогч тал \$500 –ийг төлж, “Н” компани гэрээг хаана. Энэ нь деривативийн цэвэр хэрэгжүүлэлтийн онцлог юм.

Опционы бодит үнэ цэнийн өсөлт нь “Н” компаний худалдааны бус хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг хаах буюу хамгаалж байгаа юм. Санхүүгийн тайлангууд нь “Н” компани “С” компанид оруулсан хөрөнгө оруулалтын эрсдлээ хэрхэн хамгаалсныг харуулна. Эдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнэ цэнийн бүртгэлийг ашигласнаар “Н” компани санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө оруулалт болон “Put” опционы гэрээний дүнг тайлагнаж байгаа юм.

2012/12/31 нээрх орлогын тайлал дах нөлөөг дараах байдлаар харуулав:

“Н” компани Орлогын тайлан 2012/12/31	
Бусад орлого ба зардал	
Хэрэгжээгүй олз- “Put” опцион	\$500
Хэрэгжээгүй гарз-Өмчөөрх ХО	(500)

Дээрх орлогын тайлан нь “Put” опционы олз нь өмчийн үнэ цаасны гарзыг хааж байгааг харуулж байна⁷³.

Мөнгөн урсгалын хамгаалалт

Компани мөнгөн урсгалын өөрчлөлтөөс болсон мөнгөн урсгалын эрсдлээс хамгаалахын тулд **мөнгөн урсгалын хамгаалалтыг** ашигладаг. НББОУСЗ-өөс мөнгөн урсгалын хамгаалалтын тусгай бүртгэлийг зөвшөөрдөг. Компаниуд ихэвчлэн деравативийг бодит үнэ цэнээр хэмжиж, санхүүгийн байдлын тайланд тайлагнадаг. Олз, гарзыг шууд цэвэр ашигт тайлагнана. Хэдийгээр компани санхүүгийн байдлын тайлан дах мөнгөн урсгалын хамгаалалтад бодит үнэ цэнийг ашигладаг ч, өмч дэх олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдхүүнээр бүртгэдэг.

2011 оны 9-р сард “А” компани 1000 тонн хөнгөн цагаан худалдан авахаар 2012 оны 1-р сард урьдчилан тооцоолсон. Тэд дараагийн хэдэн сард хөнгөн цагааны үнэ өснө гэж таамагласан ба “А” компани 2012 оны 1-р сард хөнгөн цагааныг өндөр үнээр худалдан авах эрсдлээс хамгаалахыг тулд энэхүү “Future” гэрээг хийж байгаа юм.

“Future” гэрээ нь тодорхой үед, тогтоосон үнээр хөрөнгийг худалдан авах эрх, үүргийг эзэмшигчдээ олгодог⁷⁴. Энэ тохиолдолд хөнгөн цагааны “Future” гэрээ нь “А” компанид 1000 тн хөнгөн цагааныг тонныг нь \$1550

⁷³ Опционы гэрээн дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт “Н” компани хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлтийг хаахгүй гэдгийг анхаарах ёстой. “С” компани хувьцааны үнэ \$125 дээш өсвөл “Н” компани “Put” опционыг хэрэгжүүлсний өгөөж хүртэхгүй юм.

⁷⁴ “Future” гэрээ нь худалдан авагч, борлуулагчийн хооронд хийгдэж буй хөрөнгийг тодорхой үед тогтоосон үнээр худалдан авах компаний гэрээ юм. Энэ гэрээ нь оролцогч 2 талаас юу худалдаалагдаж буйг мэдэж байх стандарт шалгуурууд байдаг. “Forward” гэрээ нь дээрх гэрээтэй төстэй ч стандарт нөхцлүүд байдаггүй.

худалдан авах эрх болон үүргийг өгч байна. Гэрээний үнэ гэрээний хугацаа дуусах 2012 оны 1-р сар хүртэл хүчинтэй. Энэ деривативийн суурь нь хөнгөн цагааны үнэ юм. Хэрэв хөнгөн цагааны үнэ \$1550-оос дээш өсвөл “А” компаний хувьд “Future” гэрээний үнэ цэнэ өснө. Учир нь хөнгөн цагааныг нэгж тонныг нь бага үнээр буюу \$1550-оор худалдан авах боломж “А” компанид байгаа⁷⁵.

“А” компани 2011/09/01 нд “Future” гэрээг хийсэн. 1-р сард авах барааны төлөө өнөөдөр төлж байгаа үнэ арилжааны үнэ (spot price) гэрээний үнэтэй тэнцүү юм. Энэ 2 үнэ тэнцүү учраас “Future” гэрээ нь үнэ цэнэгүй юм. Тиймээс журналын бичилт хийгдэхгүй.

2011/09/01

Журналын бичилт хийхгүй. “Future” гэрээ хийсэн талаар тэмдэглэл хийнэ. 2011/12/31 нд 1-р сард хүргэгдэх хөнгөн цагааны үнэ нэгж нь \$1575 болж өссөн гэвэл “Future” гэрээний үнэ цэнийн өсөлтийг бүртгэх дараах журналын бичилтийг хийнэ:

2011/12/31

Дт “Future” гэрээ	25000	
Кт Хэрэгжээгүй олз-Өмч		25000
(\$1575-\$1500)*1000		

“А” компани “Future” гэрээг санхүүгийн байдлын тайландаа эргэлтийн хөрөнгөөр тайлагнана. Хэдийгээр “А” компани барааг худалдан авч борлуулаагүй ч ирээдүйн гүйлгээнээс олз олох нь харагдаж байна. Энэ төрлийн гүйлгээний үед компани “Future” гэрээний олз, гарзыг өмчид бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдхүүнээр бараа зарагдах хүртэл хуримтлуулан бүртгэнэ.

2012/01 сард 1000 тонн хөнгөн цагааныг нэгжийг нт \$1575-оор худалдан авсан гэвэл

2012/01

Дт Хөнгөн цагаан-Бараа материал	1575000	
Кт Мөнгө (\$1575*1000)		1575000

Үүнтэй зэрэгцээд “Future” гэрээний эцсийн хугацаа дуусаж байгаа тул дараах журналын бичилтийг хийнэ:

2012/01

Дт Мөнгө 25000

⁷⁵ Өмнөх “Call” опционтой адил хөнгөн цагааныг бодитоор худалдан авах шаардлагагүй. Үүний оронд оролцогч талууд ирээдүйн үнэ болон гэрээний үнэ 2-ын зөрүүгээр төлбөрийг хийдэг.

Кт “Future” гэрээ 25000
 “А” компани бараа материалын өртгийг \$25000-оор худалдан авсан бараа \$1575000 бууруулж, засварлана. Үүний дүнд цэвэр мөнгөн урсгал нэгж тонн нь \$1550 болох юм.

Энэ үед ямар нэгэн орлогын нөлөө байхгүй юм. Харин “А” компаний хуримтлуулан бүртгэсэн “Future” гэрээний олзыг өмч дэх бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдхүүнд барааг борлогдох хүртэл хуримтлуулан бүртгэнэ. Жишээ нь “А” компани хөнгөн цагаанаар бэлэн бүтээгдхүүн үйлдвэрлэдэг. Бэлэн бүтээгдхүүний нийт өртөг (2012/01 сард худалдан авсан хөнгөн цагаан орсон) \$1700000. “А” компани 2012/07 сард бэлэн бүтээгдхүүнийг \$2000000 борлуулсан гэвэл

2012/07

Дт Мөнгө	2000000	
Кт Борлуулалтын орлого	2000000	
Дт Борлуулсан Бүтээгдхүүний Өртөг	1700000	
Кт Бараа-Бэлэн бүтээгдхүүн		1700000

Мөн хамгаалалттай холбоотой дараах гүйлгээг хийнэ:

Дт Хэрэгжээгүй олз-Өмч	25000	
Кт Борлуулсан Бүтээгдхүүний Өртөг		25000

“Future” гэрээний энэхүү олз нь одоо Борлуулсан Бүтээгдхүүний Өртгийг бууруулж байна. Үүний үр дүнд хөнгөн цагааны өртөг \$1550000 болж, “Future” гэрээ төлөвлөж байснаараа хэрэгжиж байгааг харуулна.

5. Бусад тайлагналын асуудлууд

Өмнөх жишээнүүдээр деравативийн бүртгэлтэй холбоотой үндсэн тайлагналын асуудлыг тайлбарласан бол одоо нэмэлт дараах асуудлуудыг авч үзье.

1. Шингэсэн (embedded) деравативийн бүртгэл
2. Хамгаалалтын шалгуур үзүүлэлтүүд

Шингэсэн (embedded) деравативийн бүртгэл

Санхүүгийн хэрэглүүрийн хөгжил дэх шинэчлэл нь деравативийн бүртгэлийн стандартыг сайжруулахыг шаардсаар ирсэн юм. Энэ шинэчлэлийн нэг хэсэг нь холимог үнэт цаасны хөгжил юм. Эдгээр холимог үнэт цааснуудад өрийг болон өмчийн шинжүүд хамтдаа байдаг ба эдгээр нь үргэлж уламжлалт болон дераватив санхүүгийн хэрэглүүрийн холимог шинжтэй байдаг. Жишээ нь: Хөрвөх бонд бол холимог хэрэглүүр бөгөөд 2 хэсгээс бүрддэг: (1) Өрийн үнэт цаас буюу гол үнэт цаас (2) бонд энгийн хувьцаанд хөрвөх опцион буюу шингэсэн (embedded) дераватив юм.

Шингэсэн (embedded) деравативийн бүртгэлд бусад деравативийн бүртгэлтэй төстэй аргуудыг хэрэглэх ба гол үнэт цааснаас шингэсэн деравативийг салган бүртгэх ба үүнийг салаалах (bifurcation) гэдэг. Гэсэн хэдий ч Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ) салаалах аргын төвөгтэй байдлыг авч үзээд шингэсэн дераватив болон гол үнэт цаас гэж нэг нэгж болгон бүртгэхийг шаардах болсон⁷⁶. Үүний бүртгэл нь гол үнэт цаасны ангилалаас хамаарна.

Хамгаалалтын шалгуур үзүүлэлтүүд

НББОУСЗ-өөс хамгаалалтын гүйлгээг хийхээс өмнө хангасан байх тодорхой шалгууруудыг тодорхойлсон байдаг. НББОУСЗ өөр өөр хамгаалалтын гүйлгээнүүдийн бүртгэлийн тогтвортой байдлыг хангахын тулд эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг тогтоожээ.

1. **Баримтжуулалт, эрсдлийн удирдлага, тодорхойлолт.** Хамгаалалтын эхний үед хамгаалалтын албан ёсны баримт бичгүүд, компаний эрсдлийн удирдлагын зорилго, түүнийг хэрэгжүүлэх стратеги байх ёстой. Тодорхойлолтоор хамгаалалтын хэрэглүүр, хамгаалах зүйл эсвэл гүйлгээ, хамгаалсан эрсдлийн шинж байдал, бодит үнэ цэнэ болон мөнгөн урсгалын аргууд нь хэрхэн эрсдлээс хамгаалж, хэрэгжих талаар харуулна. НББОУСЗ-өөс баримтжуулалт болон тодорхойлолт нь хамгаалалтын тусгай НББ-ын хэрэгжүүлэхэд чухал гэж үздэг. Эдгээр шаардлагуудын хангахгүйгээр компани хамгаалалтын бүртгэлийн нөөцийг буцаан бүртгэх ба зөвхөн зах зээлийн сөрөг өөрчлөлтөд хариу өгөх эсвэл санхүүгийн тайлангуудын сөрөг нөлөөг арилгах боломжтой юм. Иймэрхүү байдлаар тусгай хамгаалалтын бүртгэлийг ашиглах нь анхны гүйлгээний шинж байдлыг алдагдуулах аюултай байдаг.
2. **Хамгаалалтын хамаарлын үр ашигтай байдал.** Хамгаалалтын эхний болон үргэлжлэх үед хамгаалалт нь бодит үнэ цэнэ эсвэл мөнгөн урсгалын өөрчлөлтөөс хамгаалах хамгийн үр ашигтай байдлыг хангах ёстой. Компани санхүүгийн тайланг бэлтгэх бүртээ үр ашигт байдлыг үнэлж байр ёстой. Үр ашигт байдлын ерөнхий дүрэм бол хамгаалалтын хэрэгсэл (дераватив) болох бодит үнэ цэнэ болон мөнгөн урсгал, хамгааллагдсан зүйл 2-ын хамаарлын зэргийг харуулах явдал байдаг. Практикт үр ашигт байдал өндөр байгааг хамаарал 1-д (± 0.1 дотор эсвэл хамгаалалтын гүйлгээний олз, гарзын харьцаа 0.8 аас 1.25 хооронд байх) ойрхон байх гэж үздэг. Өмнө авч үзсэн хамгаалалтын жишээнүүд (“Put” опцион болон хөнгөн цагааны “Future” гэрээ)-ийн хувьд бодит үнэ цэнэ, мөнгөн урсгалууд нь маш сайн хамааралтай байсан. Үр ашигтай байдлын эдгээр шалгуурыг хэрэв хангаагүй бол НББОУС-аар

⁷⁶ Мөн компани деравативийг хамгаалалтийн хэрэгслээр бүртгэж болно.

хамгаалалтын тусгай бүртгэлийг зөвшөөрөхгүй. Энэ үед компани чөлөөт деравативийг бүртгэлтийг хийх ёстой байдаг⁷⁷.

3. **Бодит үнэ цэнэ болон мөнгөн урсгал дахь өөрчлөлтөөс олсон тайлагнасан ашгийн нөлөө.** Хамгаалагдсан зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлт эсвэл хамгаалагдсан гүйлгээний мөнгөн урсгалын хэлбэлзэл нь ихээхэн хэмжээгээр тайлангийн үеийн ашигт нөлөөлдөг. Хэрэв компани хамгаалалтын хэрэглүүр болон бодит үнэ цэнээр хамгаалагдсан зүйлийг одоо байгаа СТОУС-аар бүртгэж байгаа бол тусгай хамгаалалтын бүртгэл хэрэггүй юм. Энэ тохиолдолд хамгаалалтаас олсон ашиг нь олз, гарзад нөлөөлнө. Жишээ нь үнэт цаасны бодит үнэ цэнийн хамгаалалтын хувьд тусгай бүртгэл хэрэггүй учир нь компани хөрөнгө оруулалт, деравативийг санхүүгийн байдлын тайландаа бодит үнэ цэнээр бүртгэж, олз гарзыг ашгаар тайлагнадаг. Тиймээс СТОУС-аар “Тусгай” хамгаалалтын бүртгэл зөвхөн хамгаалалтын хэрэглүүр болон хамгаалагдсан зүйлийн бүртгэлийн нөлөө уялдахгүй үед л хэрэгтэй байдаг.

Деравативийн бүртгэлийн хураангуй

Деравативийн хэрэглээ	Деравативийн бүртгэл	Хамгаалагдсан зүйлийн бүртгэл	Түгээмэл тохиолдлууд
Наймаа	Бодит үнэ цэнээр бүртгэх ба хэрэгжээгүй олз, гарзыг орлогын тайланд бүртгэнэ.		“Call” опцион эсвэл өмчийн үнэт цаасны “Put” опцион
Бодит үнэ цэнийн хамгаалалт	Бодит үнэ цэнээр бүртгэх ба олз, гарзыг орлогын тайланд бүртгэнэ.	Бодит үнэ цэнээр бүртгэх ба олз, гарзыг орлогын тайланд бүртгэнэ.	Худалдааны бус өмчөөрх хөрөнгө оруулалтыг хамгаалах “Put” опцион
Мөнгөн урсгалын хамгаалалт	Бодит үнэ цэнээр бүртгэх ба хэрэгжээгүй олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх ба хамгаалагдсан гүйлгээний мөнгөн урсгал ашигт нөлөөлөх үед орлогын тайланд дахин ангилж оруулна.	Хамгаалагдсан зүйлийн бусад СТОУС-ийг ашиглана.	Ирээдүйн бараа материалын худалдан авалтыг хамгаалах “Future” гэрээг ашиглах

⁷⁷ Бодит үнэ цэнэ нь үр ашиггүй, олз гарз нь орлогын тайланд бүртгэгддэг деравативийн бүртгэлийн нэг хэсэг юм.

Дээр үзүүлснээс харахад деравативийн ерөнхий бүртгэл нь бодит үнэ цэнээс хамаарч байна. Мөн НББОУСЗ-өөс хэрэв компани деравативийг хамгаалалтын зорилгоор ашиглаж байгаа үед хэрэглэх тусгай бүртгэлийн заавраар хангасан байна. Жишээ нь компани худалдааны бус өмчөөрх хөрөнгө оруулалтын үнийн өөрчлөлтөөс хамгаалахын тулд “Put” опционыг ашиглаж байгааг өмнөх жишээнээс харж болно. Энд хөрөнгө оруулалт дах хэрэгжээгүй олзыг ашигт бүртгэсэн ба энэ нь СТОУС-аар хамгаалалтын бус энэ төрлийн хөрөнгөнд зөвшөөрөгддөггүй. Санхүүгийн байдлын тайлан (хөрөнгө оруулалт болон “Put” опционыг оль алийг нь бодит үнэ цэнээр бүртгэх)болон орлогын тайланд (нэг тайлант үед олз, гарзыг харилцан суутган тайлагнах) хамгаалалтын хамаарлын байдлыг үнэн зөв тайлагнахын тулд энэ тусгай бүртгэлийг хэрэглэдэг.

Тусгай бүртгэл нь мөн мөнгөн урсгалын хамгаалалтад ашигладаг. Компани санхүүгийн байдлын тайланд мөнгөн урсгалын хамгаалалтын деравативийг ашиглахдаа бодит үнэ цэнээр бүртгэх ба хэрэгжээгүй олз гарзыг хамгаалагдсан зүйл борлогдох эсвэл хэрэгжих үе хүртэл бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ. Мөнгөн урсгалын хамгаалалтанд компани хамгаалагдсан зүйлийг бүртгэхдээ түүхэн өртгийг ашиглана.

Деравативийн тодруулгын шаардлагууд ихээхэн төвөгтэй байдаг. Бодит үнэ цэнийн болон санхүүгийн хэрэглүүрийн сүүлийн үед гарсан тунхаглалууд нь санхүүгийн хэрэглүүрийн тайлагалын тодруулгын үзэл баримтлалд ихээхэн ач холбогдолтой болсон. Ерөнхийдөө деравативийг ашиглаж буй компаниуд түүнийг эзэмшиж буй зорилго эсвэл гаргах болсон шалтгаан, хамгаалалтын агуулга, эрсдлийн удирдлагын зорилгод хүрэх стратеги зэргийг тодруулахыг шаарддаг байна.